Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### ***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхтэй холбоотой Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна..

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 290.6 сая төгрөгөөр буюу 8.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/сая төгрөгөөр/

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	606.4	1,028.9	422.5
Авлага	229.5	102.5	-127.0
Урьдчилгаа		10.0	10.0
Бараа материал	120.6	53.4	-67.2
Нөөцийн бараа	39.9	31.0	-8.9
Үндсэн хөрөнгө	2,302.7	2,363.9	61.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,299.2</b>	<b>3,589.8</b>	<b>290.6</b>
Өр төлбөр	62.3	885.4	823.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,236.9	2,704.4	-532.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,299.2</b>	<b>3,589.8</b>	<b>290.6</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,028.9 сая төгрөг болж, өмнөх оноос 422.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	606.4	1,028.9	422.5
<b>Төгрөг</b>	<b>606.4</b>	<b>1,028.9</b>	<b>422.5</b>
Төрийн сангийн харилцах	606.4	1,028.9	422.5
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0	0	0.00
<b>Дүн</b>	<b>606.4</b>	<b>1,028.9</b>	<b>422.5</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэл оны эхнээс 422.5 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлогын данс, ОНХС, ХХС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Орон нутгийн ерөнхий орлогын данс 297.8 сая төгрөгийн, ОНХС-гийн данс 514.8 сая төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн данс 216.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 229.5 сая төгрөг болж, өмнөх оноос 81.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	8.1	8.1	0
Хувь хүмүүст олгосон зээл	221.4	94.4	-127.0
<b>Дүн</b>	<b>229.5</b>	<b>102.5</b>	<b>-127.0</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 127.0 сая төгрөгөөр буурсан нь хувь хүмүүст олгосон зээлийн үлдэгдэл 127.0 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

ХХС-аас тайлант онд зээл олгоогүй бөгөөд оны эцэст ХХС-ийн зээлийн 94.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Байгууллагаас авах авлага дансанд 2017 онд аймгаас дутуу авсан санхүүгийн дэмжлэгийн 2.9 сая төгрөгийн, ОНХС-ийн 2016-2018 оны дутуу санхүүжилттэй холбоотой 5.1 сая төгрөгийн бүгд 8.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэл барагдаагүй байна.

#### Аудитын илрүүлэлт:

Дэлүүн сумын Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар он дамжсан барагдах боломжгүй болсон 5,094.9 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагын үлдэгдлийг санхүүгийн тайлангаас хасч залруулсан байна.

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал данс оны эхэнд үлдэгдэлгүй ба оны эцэст 10.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0.00	10.0	10.0
<b>Дүн</b>	<b>0.00</b>	<b>10.0</b>	<b>10.0</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

#### Аудитын илрүүлэлт:

Сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Агнуур судлалын нийгэмлэг”-тэй 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр аргаль хонь, янгир ямаанд хяналтын тооллого хийх, амьтны судалгаа хийх 19.6 сая төгрөгийн гэрээ байгуулж, гэрээний урьдчилгаанд шилжүүлсэн 10.0 сая төгрөгийг санхүүгийн тайланд зардлаар бүртгэсэн”-ийг урьдчилж гарсан зардлаар залруулсан.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 120.6 сая төгрөг болж, өмнөх оноос 17.4 сая төгрөгөөр өссөн байна.

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	0.4	0.5	0.1
Аж ахуйн материал	9.4	8.8	-0.6
Бусад хангамжийн материал	42.3	38.3	-4.0
Мал амьтад	68.5	5.8	-62.7
<b>Дүн</b>	<b>120.6</b>	<b>53.4</b>	<b>-67.2</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Бараа материалын данс 67.2 сая төгрөгөөр буурсан нь сумын ЗДТГ-ын бусад хангамжийн материал болон мал амьтад дансны үлдэгдэл буурсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар бараа материалын данстай холбоотой зөрчил илрээгүй байна.

**3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө:**

Нөөцийн бараа дансанд оны эхэнд 39.9 сая төгрөгийн тэжээлийн үлдэгдэлтэй байсан ба оны эцсийн үлдэгдэл 31.0 сая төгрөг болж, өмнөх оноос 8.9 сая төгрөгөөр буурсан байна.

**3.4.6 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,352.2 сая төгрөг болж, өмнөх оноос 61.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>2,290.30</b>	<b>2,352.2</b>	<b>61.9</b>
Барилга, байгууламж, орон сууц	1,246.80	1,266.2	19.4
Авто-тээврийн хэрэгсэл	207.30	262.7	55.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	163.10	199.1	36.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	42.90	50.5	7.6
Зам, гүүрийн байгууламж	478.40	455.4	-23.0
Бусад үндсэн хөрөнгө	151.80	118.3	-33.5
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>12.30</b>	<b>11.7</b>	<b>-0.6</b>
Программ хангамж	4.20	3.6	-0.6
Бусад биет бус хөрөнгө	8.10	8.1	0.0
<b>Дүн</b>	<b>2,302.60</b>	<b>2,352.2</b>	<b>61.9</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Үндсэн хөрөнгийн данс өссөн нь сумын Засаг даргын тамгын газрын төсвийн хөрөнгөөр худалдан авсан 50.8 сая төгрөгийн хөрөнгө болон аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр үнэ төлбөргүй 221.5 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авсантай холбоотой байна.

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын илрүүлэлт:**

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар үндсэн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

**3.4.7 Өр төлбөр**

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 885.4 сая төгрөг болж, өмнөх оноос 823.1 сая төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ сая төгрөгөөр /	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа үйлчилгээний зардлын өглөг		1.1	1.1
Байгууллагад төлөх өглөг	62.3	884.3	822.0
<b>Дүн</b>	<b>62.3</b>	<b>885.4</b>	<b>823.1</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Өглөгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 823.1 сая төгрөгөөр өссөн нь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлтэй холбоотой 876.4 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өр төлбөр данстай холбоотой зөрчил гараагүй.

Сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2024 оны Б/19 дугаар тушаалаар орон нутгийн давсан хэсгээс ажилтнуудад олгосон 5000.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтөөс 500.0 мянган төгрөгийн орлогын албан татварыг суутгаагүй олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд нийт 1,201,976.1 мянган төгрөгийн 67 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр сумын ИТХ-ын 2024 оны 114 дугаар тогтоолоор баталсанаас төлөвлөлт, хэрэгжилтийг хууль, журмын дагуу оновчтой зохион байгуулж хэрэгжүүлээгүйгээс оны эцэст Орон нутгийн хөгжлийн сангийн харилцах дансанд 514,771.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа боловч 43 төсөл, арга хэмжээтэй холбоотой 876,981.1 мянган төгрөгийн өглөгтэй гарсан,

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг босго үнэд багтаах зорилгоор төсөвт байгууллагын зөөлөн эдлэл худалдан авах 17,500.0 мянган төгрөгийн ажлын төсөвт өртгийг 3 хувааж, 9 дүгээр багт хүүхдийн биеийн тамирын талбай барих 39,000.0 мянган төгрөгийн ажлын төсөвт өртгийг 2 хувааж ИТХ-ын тогтоолоор батлуулан, гэрээ шууд байгуулах замаар гүйцэтгүүлсэн зөрчилд албан шаардлага өгсөн.

**3.4.8 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,589.8 сая төгрөг болж, тайлант оны үр дүнгийн хэмжээгээр 532.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ сая төгрөгөөр /	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,236.9</b>	<b>2,704.3</b>	<b>532.5</b>

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	744.10	744.1	0.0
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,380.20</b>	<b>1,847.6</b>	<b>-532.5</b>
Өмнөх үеийн үр дүн	2,062.90	2,380.1	317.3
Тайлант үеийн үр дүн	317.30	532.5	-849.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	112.60	112.6	0.00
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,236.90</b>	<b>3,589.8</b>	<b>290.6</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Дэлүүн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан нийтдээ 3,668.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,852.9 сая төгрөгийг урсгал зардалд, 815.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд баталжээ.

Нийт зардлын 428.5 сая төгрөгийг улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр, 1,986.2 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвийн орлогоос, 701.9 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр, 175.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 113.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс бүрдүүлэхээр төлөвлөжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд гүйцэтгэлээр нийтдээ 3,357.3 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс улсын төсвөөс 428.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, сумын орон нутгийн төсвөөс 1,986.2 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 673.2 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 127.1 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой 56.6 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан ба орон нутгийн хөгжлийн сангаас 28.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, үндсэн үйл ажиллагааны орлого 47.9 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,792.2 сая төгрөг буюу 76 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлого болон орон нутгийн хөгжлийн сан 514.8 сая төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сан 216.4 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байгаатай тус тус холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт

Сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зөрчил гараагүй. Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар:

-Засаг даргын тамгын газрын сахиулд тайлант онд долоо хоногийн амралтын өдөр ажилласны нэмэгдэл хөлсөнд нийт 16,717.8 мянган төгрөгийн цалинг олгож төрийн

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**албан хаагчид нэмэгдэл хөлс олгох хувь хэмжээг хэтрүүлсэн” зөрчилд албан шаардлага өгсөн.**

- Сумын орон нутгийн орлогын давсан хэсгээс байгаль хамгаалах санд хуваарилсан хөрөнгөнөөс ан амьтны тоо толгойн судалгаа хийх гэрээний урьдчилгаанд “Агнуур судлалын нийгэмлэг”-т 10.0 сая шилжүүлж, үр дүнг тооцоогүй байсан зөрчилд зөвлөмж өгсөн.

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, Сайко инвест ХХК-аас 17.7 сая төгрөгийн, “Табигат” хоршооноос 12.0 сая төгрөгийн, нийтдээ 29.7 сая төгрөгийн хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авч, төрийн цахим худалдан авалтын журмыг хэрэгжүүлээгүй зөрчилд зөвлөмж өгсөн.

### **Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:**

Аймгийн ИТХ-ын хуралдааны “2024 оны төсөвт тодотгол хийх тухай” 2024 оны 262 дугаар тодотголоор 2,049.9 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Сумын ИТХ-ын 2024 оны 103 дугаар тогтоолоор Дэлүүн сумын 2024 орлогын төлөвлөгөөг 1,389.8 сая төгрөгөөр баталж, сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 104. дүгээр тогтоолоор 2024 орлогын төлөвлөгөөг анх баталснаас 385.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,774.9 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны “2024 оны төсөвт тодотгол хийх тухай” 2024 оны 262 дугаар тодотголоор 2,049.9 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Гүйцэтгэлээр тайлант онд 1,986.2 сая төгрөгийн орлого оруулсан ба орлогын төлөвлөгөө 63.8 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар тасарсан байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварын орлогоос ХХОАТ-ын буцаан олголтод 62.4 сая төгрөг олгосон байна.

### **Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**

<u>Үзүүлэлт</u>	<u>Төлөвлөгөө</u>	<u>Гүйцэтгэл</u>	<u>Өсөлт/+, бууралт /-/ /сая төгрөг/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
I.Татварын орлого	2,042.7	1,956.8	-85.8	98.5%
II.Татварын бус орлого	7.3	29.3	22.1	1.4%
<b>Нийт дүн</b>	<b>2,049.9</b>	<b>1,986.2</b>	<b>-63.8</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Аудитын судалгаа

Орон нутгийн орлогын төлөвлөгөө тасарсан нь ХХОАТ-ын орлого 68.1 сая төгрөгөөр, бусад татвар 28.8 сая төгрөгөөр, байгалийн нөөц ашигласны төлбөр 64.9 сая төгрөгөөр тасарсан нөлөөлсөн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд:

Татварын орлогоос хувь хүний орлогын албан татвар нийт дүнгээрээ 38.8 сая төгрөгөөр тасарсаны дотор цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар 145.2 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогын албан татвар 2.8 сая төгрөгөөр тасарч, үйл ажиллагааны албан татвар 72.6 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогын татвар 5.9 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн татвар 1.5 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна.

Өмчийн татвар нийт дүнгээрээ 75.9 сая төгрөгөөр давж биелэгдсэний дотор бууны албан татвар 0.4 сая төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 75.5 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусад татвар нийт дүнгээрээ 28.8 сая төгрөгөөр тасарсаны дотор улсын тэмдэгтийн хураамж 15.7 сая төгрөгөөр, газрын төлбөр 3.7 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 7.8 сая төгрөгөөр, хог хаягдлын хураамж 1.6 сая төгрөгөөр тасарсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөр болох агнуурын нөөцийн төлбөр 64.9 сая төгрөгөөр тасарсан.

Татварын бус орлого буюу хүү, торгуулийн орлого нийт дүнгээрээ 22.1 сая төгрөгөөр давж биелэгдсэний дотор хүү, торгуулийн орлого 5.2 сая төгрөгөөр, нэр заагдаагүй бусад орлого 16.9 сая төгрөгөөр давж биелэгджээ.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 440.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 1,986.2 сая төгрөгийн татварын орлого оруулж, аймгаас 428.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, орлого төвлөрүүлэлтээс 101.1 сая төгрөг орж нийт 2,515.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 2,658.1 сая төгрөгийн төсвийг зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 297.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар:

*/сая төгрөг/*

№	Байгууллагын нэр	2024 оны		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	дүнгээр	хувиар
1	Сумын ИТХурал	355.8	329.1	-26.6	93%
2	Сумын ЗДТГазар	1,519.7	1,386.4	-133.3	91%
3	Хоршоог хөгжүүлэх сан	175.0	0.9	-174.1	1%
4	ОНХСан	815.2	274.5	-540.7	34%
	<b>Орон нутгийн дүн</b>	<b>2,865.6</b>	<b>1,990.9</b>	<b>-874.7</b>	<b>69%</b>
1	Ерөнхий боловсролын 1-р сургууль	477.6	477.2	-0.4	99.9%
2	Ерөнхий боловсролын 2-р сургууль	28.7	28.5	-0.1	99.6%
3	Ерөнхий боловсролын 3-р сургууль	21.0	20.3	-0.6	96.9%
4	Хүүхдийн 1-р цэцэрлэг	50.2	50.2	-	100%
5	Хүүхдийн 2-р цэцэрлэг	20.2	20.2	-	100%
6	Хүүхдийн 3-р цэцэрлэг	64.5	64.49	-0.01	100%
7	Соёлын төв	70.9	70.9	-	100%
8	Эрүүл мэндийн төв	69.5	69.5	-	100%
	<b>Бусад байгууллагын дүн</b>	<b>802.6</b>	<b>801.4</b>	<b>-</b>	<b>99.9%</b>
	<b>Нийт дүн</b>	<b>3,668.2</b>	<b>2,792.4</b>	<b>875.8</b>	<b>76.1</b>

*Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд нийт 3,668.2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 2,792.4 сая төгрөгийн төсвийг зарцуулж 76.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнд: Сумын ИТХ 26.6 сая, ЗДТГ 133.3 сая, Хоршоог хөгжүүлэх сан 174.1 сая, Орон нутгийн хөгжлийн сан 540.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Сумын ЗДТГ 1,519.7 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 1,386.4 сая төгрөгийн санхүүжилт авч төсвийн нийт зарлага 91 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь орон нутгийн төсвөөс 60.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, 73.3 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Сумын ИТХ 355.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 329.1 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж 93 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сумын Орон нутгийн хөгжлийн сан төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь зарцуулалттай, Хоршоог хөгжүүлэх сан төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь зээлийн эргэн төлөлтөөс орсон орлогын гүйцэтгэлтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 8.0 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 15.9 сая төгрөгийн нийтдээ 23.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна. Үүнээс: Тээвэр шатахууны зардалд 2.6 сая төгрөгийг, дотоод томилолтын зардалд 1.9 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 19.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайланг 2024 оны 3 дүгээр сарын 06-ны өдрийн 01/72 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгө 3,299.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 49.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд үйл ажиллагаатай хамааралтай 2 шалгуурт алдаа, зөрчил илрээгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувь, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 92.5 хувьтай байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчид завсрын аудит хийгдээгүй.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн** Өмнөх 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

#### **5.1. Сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн талаар:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Рашаант, Хүйтэн нуур багийн сургууль, Хүүхдийн 1, 2, 3 дугаар цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 635.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 15.1 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 0.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 590.5 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгах 3 албан шаардлага, 29.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 зөвлөмж өгөгдсөн.

Сумын бусад төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 8,109.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 7,246.6 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 11.8 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 790.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага, 61.3 сая төгрөгийг зөрчлийг арилгах 6 зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт №4: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дэлүүн сумын ЗДТГ	4	58.90	1	10.0			2	19.2	1	29.7
2	Дэлүүн сумын ИТХ	1	0.50			1	0.5				
3	Дэлүүн сумын ОНХС	2	576.40	1	5.1			1	571.3		
4	Дэлүүн сумын ХХС	0	-								
<b>Орон нутгийн байгууллагын дүн</b>		<b>7</b>	<b>635.80</b>	<b>2</b>	<b>15.1</b>	<b>1</b>	<b>0.5</b>	<b>3</b>	<b>590.5</b>	<b>1</b>	<b>29.7</b>
1	Дэлүүн сумын ЕБС-ын 1 дүгээр сургууль	8	7,447.30	3	6,659.60			4	787.7	1	
2	Дэлүүн сумын Рашаант багийн сургууль	2	7.80	1	7.8					1	
3	Дэлүүн сумын Хүйтэн нуур багийн сургууль	1	-							1	
4	Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэг	0	-								
5	Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэг	2	190.90	1	188.4			1	2.5		
6	Дэлүүн сумын 3 дугаар цэцэрлэг	0	-								
7	Дэлүүн сумын Соёлын төв	3	4.90	1	4	1	0.2			1	0.7
8	Дэлүүн сумын Эрүүл мэндийн төв	12	459.00	7	386.8	2	11.6	1		2	60.6
<b>Бусад байгууллагын дүн</b>		<b>28</b>	<b>8,109.90</b>	<b>13</b>	<b>7,246.60</b>	<b>3</b>	<b>11.8</b>	<b>6</b>	<b>790.2</b>	<b>6</b>	<b>61.3</b>
<b>Нийт дүн</b>		<b>35</b>	<b>8,745.70</b>	<b>15</b>	<b>7,261.70</b>	<b>4</b>	<b>12.3</b>	<b>9</b>	<b>1,380.70</b>	<b>7</b>	<b>91.0</b>

Эх сурвалж: Аудитын зөрчлийн мэдээ

Аудитын дүнгээр Сумын Засаг дарга, Санхүүгийн албад дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

1.Сумын төсөвт байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчилд өгсөн 12.3 сая төгрөгийн 4 төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулах, 1,380.7 сая төгрөгийн 9 албан шаардлага, 91.0 сая төгрөгийн 7 зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллах;

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**5.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар:**

Сумын ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй, алдаа зөрчил илрээгүй болно.

**5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй.

**5.2 Албан шаардлага**

Албан шаардлага өгөгдөөгүй.

**5.3 Зөвлөмж**

Аудитаар сумын ТТЗ-д 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ-ийн харьяа байгууллагуудад өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнах	1						1					

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн	1				1				
-----	---	--	--	--	---	--	--	--	--

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
<b>Нийт дүн</b>								